Улсын ерөнхий прокурорын 2026 оны
06 дугаар сарын 09-ний өдрийн
А/95 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

√	Прокурорын байгууллагын бүтцийг шинэчлэн батлагдсан

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:	Төрийн албаны тухай хууль 2017-12-07
Дагаж мөрдөх огноо:	2019-01-01
Албан тушаалын тодорхойлолтыг батлагдсан огноо:	2026-06-09

Байгууллагын нэр:	Нэгжийн нэр:
Улсын ерөнхий прокурорын газар	Хэрэг эрхлэх газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс

Албан тушаалын нэр:	Албан тушаалын ангилал, зэрэглэл:
Хэрэг эрхлэх газрын дэд бөгөөд Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, ахлах прокурор	Төрийн тусгай

Ажлын цаг:	Ажлын байрны албан ёсны байршил:
Ажлын өдрийн 8 цаг	Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу, Хуульчдын гудамж 15/1

Хөдөлмөрийн нөхцөл:	Онцгой нөхцөл:
Хэвийн	**Хамаарахгүй**

II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Прокурорын байгууллагын үйл ажиллагааны хэвийн тасралтгүй байдлыг хангах дунд болон урт хугацааны төсвийг төлөвлөх, гүйцэтгэлийг хангуулах, нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, санхүүгийн нэгдсэн удирдлагаар хангах, худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих, тайлагнах.

Албан тушаалын зорилт:
1.Прокурорын байгууллагын үйл ажиллагааны хэвийн тасралтгүй байдлыг хангахад шаардлагатай төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийн хуваарилалт, зарцуулалт, тайлагнах үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах;
2.Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон бусад төслийн хөрөнгөөр хэрэгжүүлэх шаардлагатай ажил, арга хэмжээг төлөвлөх, худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, хэрэгжүүлэх;
3.Прокурорын байгууллагын нягтлан бодох бүртгэлийг дотоодын хууль тогтоомж, стандартад нийцүүлэх ажлыг зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах;
4.Хэлтсийн үйл ажиллагааг өдөр тутмын мэргэжлийн удирдлагаар хангах, гүйцэтгэлд хяналт тавих.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.1.Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төслийн танилцуулга, төсвийн хязгаарын саналыг боловсруулж, төсвийн багцыг төлөвлөн танилцуулах.	Төсвийн багцыг төлөвлөн танилцуулсан байна.	Г, Х
	1.2.Прокурорын байгууллагын батлагдсан төсвийн хуваарилалтын талаар санал боловсруулж, батлуулах.	Санал боловсруулж, танилцуулсан байна.	Г, Х
	1.3.Прокурорын байгууллагын нэгдсэн төсвийн хүрэлцээ, цаг үеийн шаардлага, үнийн өсөлт, инфляцыг харгалзан төсвийн зохицуулалт хийх саналыг танилцуулах.	Төсвийн зохицуулалт хийх санал танилцуулсан байна.	Г, Х
	1.4.Тавилга, эд хогшил, тоног төхөөрөмжийн нэгдсэн захиалгыг гаргаж үндэслэл, хэрэгцээ шаардлагыг тодорхойлон төсөвт өртгийн судалгаа хийж танилцуулах.	Төсөвт өртгийн судалгаа хийгдсэн байна.	Г
	1.5.Прокурорын байгууллагын төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр нэгтгэн гаргуулж, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.	Мэдээг хугацаанд нь гаргуулж, хүргүүлэх арга хэмжээ авсан байна.	Х, Ш
	1.6.Төсвийн ерөнхийлөн захирагчийн хагас болон бүтэн жилийн санхүүгийн тайланг нэгтгэн гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэх, ирүүлсэн санал, зөвлөмжийн хэрэгжилтийг зохион байгуулах.	Тайланг хүргүүлж, санал, зөвлөмжийн хэрэгжилтийг хангасан байна.	Г, Х, Ш
	1.7.Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийлгэх ажлыг	Аудит хийлгэж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлсэн байна.	Г, Х

	зохион байгуулах, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах.		
2 дугаар зорилтын хүрээнд	2.1.Санхүү, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбоотой судалгаа хийлгэж, авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, хяналт тавих.	Судалгаа хийлгэж, арга хэмжээ авсан байна.	Х, Ш
	2.2.Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон бусад төслийн хөрөнгөөр хэрэгжүүлэх шаардлагатай ажил, арга хэмжээг төлөвлөн, гүйцэтгэлийг хангаж, холбогдох мэдээллийг зохих байгууллагад хүргүүлэх.	Ажил арга хэмжээг төлөвлөж, мэдээллийг хүргүүлсэн байна.	Г, Х
	2.3.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулах, худалдан авах ажиллагааг зохион байгуулах, санхүүжилт олгох, хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлт, үр дүнг тооцон дүгнэх.	Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьсан байна.	Г, Х
	2.4.Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэлийг байршуулсан байдалд хяналт тавьж, мэдээг нэгтгэн тайлагнах.	Хяналт тавьж, мэдээг нэгтгэн тайлагнасан байна.	Г, Х
	2.5.Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд холбогдох мэдээллийг байршуулах ажлыг зохион байгуулах.	Мэдээллийг байршуулсан байна.	Г, Х
	2.6.Прокурорын байгууллагаас хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн барилга, байгууламж барих, худалдан авах, барилгын засварын ажлын талаар санал гаргаж танилцуулж шийдвэрлүүлэх.	Шийдвэрлүүлсэн байна.	Г, Х
	2.7.Прокурорын байгууллагаас хэрэгжүүлж буй төслүүдэд Барилгын ажил захиалагчийн дүрмийн 3 дугаар заалтын хэрэгжилтийг хангуулах.	Хэрэгжилт хангагдсан байна.	Г, Х
	2.8.Санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр холбогдох сургалтыг нэгж прокурорын газруудад зохион байгуулах.	Сургалт зохион байгуулсан байна.	Х, Ш
	2.9.Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбоотой судалгаа хийх, санал шийдвэрлэх.	Судалгаа хийж, саналыг шийдвэрлэсэн байна.	Г, Х, Ш

3 дугаар зорилтын хүрээнд	3.1.Прокурорын байгууллагын нягтлан бодох бүртгэлийг дотоодын хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарт, байгууллагын бодлогын баримт бичгийг нийцүүлэн зохион байгуулах, хяналт тавих.	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг хангасан байна.	Г, Х
	3.2.Прокурорын байгууллагын үндсэн хөрөнгийн шилжилт хөдөлгөөн, хөрөнгийн зарцуулалтын бүртгэлийн нэгдсэн мэдээ, тайланг гаргах, өмч эзэмшүүлэх гэрээг байгуулж, дүгнүүлэх ажлыг зохион байгуулах.	Зохион байгуулалтын арга хэмжээ авсан байна.	Г, Х
	3.3.Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг байршуулах ажлыг зохион байгуулах.	Зохион байгуулалтын арга хэмжээ авсан байна.	Г, Х
	3.4.Төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг бүртгэх ажлыг зохион байгуулах.	Зохион байгуулалтын арга хэмжээ авсан байна.	Г, Х
	3.5.Төсөв санхүүгийн үйл ажилалгаанд үр ашигтай мэдээллийн технологийг судалж, үр дүнг дээшлүүлэх, хөгжүүлэх ажлыг зохион байгуулах.	Ажил, арга хэмжээ зохион байгуулсан байна.	Г, Х
4 дүгээр зорилтын хүрээнд	4.1.Харьяалах захиргааны албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталгаажуулж, ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлж, дүгнэх.	Ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлж дүгнэсэн байна.	Г
	4.2.Хэлтсийн ажилтнуудыг мэргэжлийн удирдлагаар хангаж, гүйцэтгэлд хяналт тавих.	Мэргэжлийн удирдлагаар хангасан байна.	Г
	4.3.Хэлтсийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүртгэл, судалгааг хөтлүүлж, хяналт тавих.	Бүртгэл хөтлөлтөд хяналт тавьсан байна.	Г, Х
	4.4.Архив, албан хэрэг хөтлөлтийн ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, заавар, журам, стандартын хэрэгжилтийг хангах.	Хэрэгжилтийг хангасан байна.	Г, Х
	4.5.Дээд шатны прокурорын томилсноор газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэх.	Газрын үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөл хангагдсан байна.	Г
	4.6.Хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан заавар, журам, Улсын ерөнхий прокурорын тушаалаар хариуцуулсан чиг үүргийг хэрэгжүүлэх.	Хууль, заавар, журамд заасан чиг үүрэг хэрэгжсэн байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА		
Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	
Мэргэжил	Эрх зүй (0421)	
Мэргэшил	-хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээтэй байх -хуульчийн багц цагийн сургалтад хамрагдсан байх	
Туршлага	Прокуророор 5-аас доошгүй жил, үүнээс Улсын ерөнхий прокурорын газрын хяналтын прокурор, Нийслэлийн прокурорын газрын ерөнхий прокурорын орлогч, ахлах прокурор, сум дундын прокурорын газрын ерөнхий прокурор, аймаг, тээвэр, дүүргийн прокурорын газрын ерөнхий прокурор, ерөнхий прокурорын орлогчоор 3-аас доошгүй жил ажилласан.	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	-хэлтсийн үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэх; -прокурор, ажилтанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх; -эрсдлийг урьдчилан тооцоолох, гарах арга замыг тодорхойлох, эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэх.
	Дүн шинжилгээ хийх	-мэдээллийг цуглуулж, шалгаж нягтлах; -шийдвэрийн үр дагавар, эрсдлийг үнэлэх; -судалгааны арга зүйг ашиглан санал, дүгнэлт боловсруулах.
	Асуудал шийдвэрлэх	-хариуцсан ажлын явцад үүссэн асуудал, хүндрэл бэрхшээлийн шалтгаан, нөхцөлийг бодит мэдээлэлд үндэслэн тогтоох; -шийдвэрийн үр дагавар эрсдлийг урьдчилан тооцоолох; -хууль тогтоомжид нийцсэн оновчтой шийдвэр гаргах; -гаргасан шийдвэрийн хариуцлагыг хүлээх.
	Манлайлах	-прокурор, ажилтнуудыг үлгэрлэн манлайлах; -ажлын байрны зөрэг орчныг бүрдүүлэх; -шинэ санаачилга болон өөрчлөлтийг дэмжих.
	Багаар ажиллах	-хамтын шийдвэр гаргалтад идэвхтэй оролцох; -хариуцсан ажлыг багийн зорилготой уялдуулан хэрэгжүүлэх; -мэдээллийг нээлттэй хуваалцах; -бусдын санал бодлыг хүндэтгэх.
	Бусад	-баримт бичиг боловсруулах; -хууль хэрэглэх; -ажлын ачааллыг оновчтой төлөвлөж, эрэмбэлэн зохион байгуулах; -албан хэрэгцээнд шаардлагатай мэдээллийн систем, программ хангамжийг ашиглах, мэдээллийг цахим орчинд боловсруулах.

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ	
Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: 1.Газар, хэлтсийн ахлах референт, референт, нярав 2.Газар, хэлтсийн туслах ажилтан, мэргэжилтэн 3.Инженер, техникч, слесарь Нийт: 3	Бусад харилцах субъект: 1.Нэгж прокурорын газрын прокурор, ажилтан 2.Төрийн байгууллага 3.Иргэн, хуулийн этгээд

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ТУСЛАХ ПРОКУРОР, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХТУЯА 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдөр	Байгууллагын нэр: УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ДЭРГЭДЭХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН Шийдвэрийн огноо: 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Дугаар: 2
Албан тушаалын тодорхойлолт баталсан:	
Байгууллагын нэр: МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР Шийдвэрийн огноо: 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдөр Дугаар: А/95 УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР, ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ Б.ЖАРГАЛСАЙХАН 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдөр	